

БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН 2024
ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

АУДИТЫН КОД: БУА-2025/06-04-ШТА-НА

БУЛГАН АЙМАГ
2025

Булган дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор Д.Батцогт
Утас: 7034-2716 Цахим хаяг: Battsogetd@audit.gov.mn
Ахлах аудитор: Г.Намчинсүрэн
Утас: 7034-2495 Цахим хаяг: Namchinsureng@audit.gov.mn
Аудитор: А.Сувдаа
Утас: 7034-2716 Цахим хаяг: Suwdaaa@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах
хаягаар авна уу. bulgan@audit.gov.mn

Агуулга	
Товчилсон үгийн тайлбар.....	2
Хүснэгтийн товъёг.....	2
Ерөнхий мэдээлэл:.....	3
АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ.....	4
1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хууль, журамд бүрэн нийцсэн төсөл арга хэмжээг төлөвлөөгүй байна.	5
1.1 Шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний 58.7 хувь нь дунд болон богино хугацааны хөгжлийн төлөвлөлтийн баримт бичигтэй нийцсэн байна.	5
1.2 Хөрөнгө оруулалтын зарим төсөл, арга хэмжээг аргачлалын дагуу үнэлж эрэмбэлэн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцож төлөвлөөгүй байна.	5
1.3 Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хуульд заасан техник, эдийн засгийн үндэслэл, батлагдсан зураг төсвийн шаардлага хангагдаагүй арга хэмжээг тусгасан байна.....	6
2. Эрх шилжүүлсэн зарим хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулаагүй шууд худалдан авалт хийсэн байна.	7
2.1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 30.5 хувийг нээлттэй тендер шалгаруулалтаар 47.5 хувийг харьцуулалтын аргаар зохион байгуулсан байна.....	7
2.2 Зарим хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичгийн техникийн тодорхойлолт холбогдох хуулийн заалттай нийцээгүй байна.	9
2.3 Холбогдох хууль, журам, тендерийн баримт бичигт тусгасан шаардлагыг хангасан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна.....	10
3. Захиалагч нь тайлант онд хэрэгжих боломжгүй хугацаанд гэрээ байгуулснаас 2 төсөл, арга хэмжээ он дамжин хэрэгжих болсон.	10
3.1 Зарим төсөл, арга хэмжээний ажлын гүйцэтгэлд санхүүжилт олгохдоо журамд заасан баримт бичгийн бүрдлийг бүрэн бүрдүүлээгүй байна.	10
3.2 Зарим хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжүүлээгүй байна.....	12
3.3 Бүрэн хэрэгжсэн зарим хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг техникийн тодорхойлолт, ажлын тоо хэмжээ, материалын дагуу хүлээж аваагүй байна	13
3.4 Хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийг бүртгэл тайланд бүрэн тусгаагүй байна.	14
ДҮГНЭЛТ:.....	16
ЗӨВЛӨМЖ:	17

Товчилсон үгийн тайлбар

ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
ЗГ	Засгийн газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
НА	Нийцлийн аудит
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
СХЗХ	Стандарт, хэмжил зүйн хэлтэс
ТАХ	Төсөл арга хэмжээ
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үнэлгээ
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХХААГ	Хүнс хөдөө аж ахуйн газар
ХХҮГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
ШТА	Шууд тайлагнах аудит

Хүснэгтийн товъёг

Хүснэгт 1: Төсөл арга хэмжээний ангилал.....	3
Хүснэгт 2: Төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтын аргын тоон мэдээлэл....	8
Хүснэгт 3: Эрх шилжүүлсэн ТАХ-ний мэдээлэл.....	8
Хүснэгт 4: ОНХО-аар олгосон санхүүжилтийн мэдээлэл	11
Хүснэгт 5: Бүрэн хэрэгжсэн ТАХ-ээс бүртгэлд тусгасан ТАХ.....	14
Хүснэгт 6: Бүртгэлд тусгасан ТАХ /Эрх зүйн шийдвэрээр/.....	14

Ерөнхий мэдээлэл:

Булган аймгийн ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн XIV/08 тогтоолоор 2024 онд он дамжин хэрэгжиж байгаа 5, шинээр хэрэгжих 25 нийт 5,450.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий төсөл арга хэмжээг 4,275.0 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталжээ.

Анх баталсан төсөвт аймгийн ИТХ 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн XXV/05 тогтоолоор тодотгол хийж шинээр хэрэгжих 1,055.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 13 төсөл арга хэмжээг нэмж баталсан байна.

Хүснэгт 1: Төсөл арга хэмжээний ангилал

Ангилал	Шинэ ТАХ			Шилжих ТАХ			Нийт ТАХ		
	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
Барилга байгууламж	6	925.50	827.90				6	925.5	827.9
Их засвар	18	2,800.00	2800.0	4	745.5	370.5	22	3545.5	3170.5
Тоног төхөөрөмж	15	961.00	961.00	1	18.7	18.7	16	979.70	979.70
Нийт дүн	39	4686.5	4588.9	5	764.2	389.2	44	5450.7	4978.1

Эх сурвалж : АИТХ-ын 2024 оны XXV/05 дугаар тогтоолоос

Нийт санхүүжилтийн 17.0 хувийг барилга, байгууламж, 64 хувийг тоног төхөөрөмж, 20 хувийг их засварын төсөл, арга хэмжээнд тус тус зарцуулахаар төлөвлөжээ.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих 39, өмнөх оноос шилжин хэрэгжих 5 төсөл, нийт 44 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр өмнөх оноос шилжин ирсэн 4 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжиж, 1 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжээгүй, шинээр хэрэгжих 29 арга хэмжээ бүрэн хэрэгжиж, 11 төсөл арга хэмжээ тендерт оролцогч оролцохгүй байх, магадлалын ерөнхий дүгнэлтгүй, тоног төхөөрөмж нийлүүлэх, техникийн тодорхойлолт, ажлын даалгаваргүй, ТЭЗҮ-гүй төсөл, арга хэмжээг хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр батлах, тендерт оролцогч шалгараагүйгээс олон удаа зарлах, оны сүүлд гэрээг хийх зэрэг шалтгаанаар төсөл, арга хэмжээ төлөвлөгдсөн хугацаанд хэрэгжээгүй байна.

Бүрэн хэрэгжсэн 32 төсөл арга хэмжээнд 3,413.3 сая төгрөгийн санхүүжилт олгож, 105.0 сая төгрөгийг чанарын баталгааг барьцаа дансанд байршуулсан байна.

Аудитад Булган аймагт хэрэгжсэн нийт төсөл хөтөлбөрөөс төлөвлөлт, өмч ашиглалт, бүртгэлтэй холбоотой асуудлыг бүрэн, худалдан авалт, санхүүжилт, захиалагчийн хяналттай холбоотой асуудлыг аймгийн төвд хэрэгжсэн төсөл хөтөлбөрийн хүрээнд авч үзлээ.

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.5 дахь зүйлийг үндэслэн мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны 05 дугаар тогтоолд тусгасны дагуу “Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт”-д Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамжаар нийцлийн аудит хийлээ.
Аудитын зорилт	Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэсэн. Үүнд: - Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хууль, журамд заасан шаардлага хангасан төсөл, арга хэмжээг төлөвлөсөн эсэх; - Хөрөнгө оруулалтаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан эсэх; - Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль журмын дагуу санхүүжүүлж, хугацаанд нь гүйцэтгүүлэн бүртгэлд тусгасан эсэх.
Аудитын хамарсан хүрээ	Аудитыг Булган аймагт 2024 онд орон төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт төсөл, арга хэмжээний төлөвлөлт, төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын 28 төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт болон эдгээр төсөл, арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагууд, төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч нарын холбогдох үйл ажиллагааг хамруулав. Аудитын явцад объектыг түүвэрлэн барилга байгууламжийн ажлын бодит гүйцэтгэлийг газар дээр нь шалгасан.
Аудитын арга зүй,	Аудитыг АДБОУС 4000-4200, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Тулгуур зарчим”, MNS 6817-6:2020 “Нийцлийн аудитын зарчим”, MNS 6817-8:2020 “Нийцлийн аудитын стандарт”, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, дүн шинжилгээ хийх, харьцуулах, тулган баталгаажуулах, түүвэрлэн хянах зэрэг судалгааны арга зүйг ашиглан гүйцэтгэлээ.
Аудитын шалгуур үзүүлэлт	Аудитыг Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Тулгуур зарчим”, MNS 6817-6:2020 “Нийцлийн аудитын зарчим”, MNS 6817-8:2020 “Нийцлийн аудитын стандарт”, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах нотлох баримтыг цуглуулж, дүн шинжилгээ хийх, харьцуулах, тулган баталгаажуулах, түүвэрлэн хянах зэрэг судалгааны арга зүйг ашиглан дүгнэлт, зөвлөмж боловсруулав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Батцогт хянан удирдаж, аудитын менежер Ж.Энхцоодол үе шатны чанарын хяналтыг хийж, ахлах аудитор Г.Намчинсүрэн, аудитор А.Сувдаа нар хийж гүйцэтгэлээ. Аудитын удирдамжийн дагуу гүйцэтгэлийн аудитыг 2024 оны 04 дүгээр сарын 025-ний өдрөөс 2024 оны 06 дугаар сарын 23-ны өдөр хүртэл хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн ч Нийслэл дахь Төрийн аудитын газрын 05 дугаар сарын 08-ны 01/423 дугаар албан бичгийн дагуу ажлын 20 хоногт хийж аудитыг үе шатны хяналтаар хянуулж аудитын тайланг хавсралт судалгааны хамт 2024 оны 05 дугаар сарын 23-ны өдөр Нийслэл дахь Төрийн аудитын газар, аймгийн ИТХ, Засаг даргад тус тус хүргүүлэн ажиллалаа.
Хүндрэл бэрхшээл	Төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн бодит байдал, барилга угсралтын ажлын чанарт хяналт хийхэд цаг хугацааны хувьд хязгаарлагдмал /Баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн хугацаанаас өмнө гүйцэтгэх чиглэл ирсэн/ байсан ба зарим төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг цаасан нотлох баримтын хүрээнд хянасан.

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хууль, журамд бүрэн нийцсэн төсөл арга хэмжээг төлөвлөөгүй байна.

1.1 Шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний 58.7 хувь нь дунд болон богино хугацааны хөгжлийн төлөвлөлтийн баримт бичигтэй нийцсэн байна.

Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.5.¹ дах заалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5, 6 дугаар зүйлүүдийн холбогдох заалтуудад хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ нь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засаг даргын тухайн жилийн үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулж төлөвлөхөөр заажээ.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх 39 төсөл, арга хэмжээний 41.3 хувь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засаг даргын тухайн жилийн үйл ажиллагааны хөтөлбөртэй нийцээгүй байна. /Судалгааны хүснэгт-1/ Тухайлбал:

№	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Төсөвт өртөг	2024 онд санхүүжүүлэх дүн
1	0.4 КВТ цахилгаан дамжуулах шугамын ажлын санхүүжилт (Баян-Агт сум)	40.0	40.0
2	Сумын төвийн гэрэлтүүлэг (Баян-Агт сум)	50.0	50.0
3	Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн техник хэрэгсэл	8.0	8.0
4	Драйгер баталгаажуулах болон пестицид тодорхойлох эталон тоног төхөөрөмж	25.0	25.0
5	Санхүүгийн хяналт, аудитын албаны хяналт шалгалтын автомашин	50.0	50.0
6	Авто тээврийн төвийн барилгын засвар	30.0	30.0
Нийт дүн		203.0	203.0

Аймгийн ИТХ 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн XXV/05 тогтоолоор анх баталсан төсөвт тодотгол хийж шинээр хэрэгжих 1,055.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 13 төсөл арга хэмжээг нэмж баталсан байна.

УИХ-ын 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаар Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд тавигдах шаардлагад шинээр олон нийтээр хэлэлцүүлсэн байх заалт нэмэгдсэн боловч хууль батлагдсанаас хойш төсөв тодотгосон тогтоолуудад хэрэгжүүлээгүй байна.

Тодотголоор нэмж баталсан төсөл, арга хэмжээнүүд хөгжлийн бодлогын урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигтэй нийцээгүй байна.

Энэ нь цаашид хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ нь богино хугацааны үр ашиг харах, урт хугацаанд үр дүнгээ өгөх төсөл арга хэмжээ төлөвлөгдөхгүй эрсдэлтэй байгаад анхаарах шаардлагатай байна.

1.2 Хөрөнгө оруулалтын зарим төсөл, арга хэмжээг аргачлалын дагуу үнэлж эрэмбэлэн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцож төлөвлөөгүй байна.

Сангийн сайдын 2023 оны 278 тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах,

¹ тухайн жилийн төсвийн хязгаарт багтсан, хөгжлийн бодлогын зорилтуудтай уялдсан байх.

тайлагнах” журмын 2.3.2.1²-д шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төсөл арга хэмжээг тусгай шалгуур үзүүлэлтийн дагуу судлан шинжилж, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол, төслийн бэлэн байдлаар нь эрэмбэлэхийг заажээ.

Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэхээр батлагдсан 44 төсөл, арга хэмжээний 9 хувь нь буюу 4 нь эрэмбэлж үнэлээгүй төсөл, арга хэмжээ байна. Тухайлбал:

- ✚ Булган аймаг дахь Тагнуулын хэлтсийн алба хаагчдын орон сууцны төлбөр (2 ш орон сууц, 49.67 м², 58.87м²)
- ✚ Цэвэр усан хангамжийн угсралтын ажил (Рашаант сум)
- ✚ 0.4 КВТ цахилгаан дамжуулах шугамын ажлын санхүүжилт (Баян-Агт сум)
- ✚ Сумын төвийн гэрэлтүүлэг (Баян-Агт сум)

Орон нутгийн хэрэгцээ шаардлагад үндэслээгүй, тооцоо судалгаа хийгдээгүй, журмын шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээ батлагдах нь төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг бууруулах эрсдэлтэй байна.

Иймд аймгийн төсвийн Ерөнхийлөн захирагч төсөл, арга хэмжээний саналыг хүргүүлэхдээ “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх, төсөл арга хэмжээг үнэлж эрэмбэлэх үйл ажиллагаа журам”-ын холбогдох заалтыг мөрдөж ажиллах шаардлагатай байна.

Мөн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээгээг төлөвлөхдөө өмнөх оны санхүүжилтийн дутуу, нэмэлтээр ажил хийлгэх гэрээ байгуулсан төсөл арга хэмжээг шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд эрэмбэлэн төлөвлөсөн, төсөл арга хэмжээний нийт төсөвт өртөг 2 өөр эх үүсвэрээр санхүүжигдэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө нийт төсөвт өртгөөр бус тухайн эх үүсвэрээс санхүүжигдэх дүнгээр төлөвлөж байгаа нь Төсвийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.6³-д заасан заалттай бүрэн нийцээгүй байна.

Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний мэдээллийг зөрүүтэй, дутуу баталснаар иргэд, олон нийт бодитой, үнэн зөв мэдээллээр хангагдахгүй байх, байнгын ашиглагч байгууллагын бүртгэл тайланд алдаатай илэрхийлэгдэх эрсдэл байгаад анхаарч төлөвлөлтийг холбогдох хуульд бүрэн нийцүүлэх зөвлөмжийг хүргүүллээ.

1.3 Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хуульд заасан техник, эдийн засгийн үндэслэл, батлагдсан зураг төсвийн шаардлага хангагдаагүй арга хэмжээг тусгасан байна.

Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3⁴, 29.4⁵, 29/1 дүгээр зүйлийн 29/1.1, 29/1.2, Барилгын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.11⁶ дэх заалтууд,

² орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөгөөг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний холбогдох маягт, ангилалтай ижил байдлаар хэрэгжүүлж, тайлагнах;

³ хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар /нэр, байршил, хүчин чадал, төслийн код, хэрэгжүүлэх хугацаа, төсөвт өртөг, анхны төсөвт өртөг, санхүүжүүлэх эх үүсвэр, тухайн төсвийн жилийн санхүүжилтийн дүн/;

⁴ Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны Засаг дарга, хот, тосгоны Захирагч хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт саналыг дараах байдлаар жилийн төсвийн төсөлд тусгана ...;

⁵ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана

⁶ зураг төсөлгүй барилга байгууламжийг улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгуулахгүй байх;

Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-д шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсөвлөлтийн шаардлагыг тусгажээ.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн шинээр хэрэгжүүлэх барилга, байгууламж барих, их засвар, тоног төхөөрөмж нийлүүлэх 6 төсөл, арга хэмжээ нь зураг, төсөвгүй, 9 төсөл арга хэмжээ нь магадлалын ерөнхий дүгнэлтгүй, зарим тоног төхөөрөмж нийлүүлэх, техникийн тодорхойлолт, ажлын даалгаваргүй 1 төсөл арга хэмжээг төлөвлөсөн байна. /Хавсралт-1, Судалгааны маягт-1/

Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 -т заасны дагуу техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвийг батлуулсан байх шаардлагыг хангаагүй төсөл, арга хэмжээг ИТХ-аар баталдаг, батлагдсанаас хойш техник зураг төсвийг боловсруулдаг нийтлэг зөрчил гарсаар байна.

Дээрх зөрчлүүд жил бүрийн аудитаар давтагдан гарч байгаа нь төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг алдагдуулж, төсвийн төлөвлөлтийн зарчим хангагдахгүй байгааг харуулж байна.

ИТХ-ын хэлэлцүүлгийн явцад өөрчлөн баталж буй нь хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хэрэгжих ажлын цар хүрээ, хийгдэх ажлын тоо хэмжээ тодорхой бусаас санхүүжилт дутагдах, үргүй зардал гаргах, тухайн төсөл арга хэмжээ хугацаандаа хийгдэхгүй байх, дахин санхүүжилт шаардлагатай болох эрсдэлтэй байгаад анхаарч холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хөрөнгө оруулалтыг төлөвлөх шаардлагатай байгаад анхаарч ажиллах зөвлөмжийг ИТХ-д хүргүүлжээ.

2. Эрх шилжүүлсэн зарим хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулаагүй шууд худалдан авалт хийсэн байна.

2.1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 30.5 хувийг нээлттэй тендер шалгаруулалтаар 47.5 хувийг харьцуулалтын аргаар зохион байгуулсан байна.

Аймгийн худалдан авах ажиллагааны газар нь ТБОНӨХБАҮХАТХ -ийн 44.4⁷, Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журмын 3.2-д⁸ заасны дагуу худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг нэгтгэн баталгаажуулан цахим системд нийтэлжээ.

ТБОНӨХБАҮХАТХ-ийн 9.1⁹, 31.1¹⁰ -д заасны дагуу нээлттэй болон, харьцуулалтын аргаар худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа ил тод байдлыг хангаж цахим системээр зохион байгуулсан байна.

⁷ Төсвийн ерөнхийлөн захирагч тухайн жилийн санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш нэг сарын дотор харьяа захиалагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг нэгтгэн хянаж, баталгаажуулан цахим системд нийтэлнэ"

⁸ Захиалагч тухайн жилийн төлөвлөгөөг батлагдсан нийт төсөвт үндэслэн төсөл, арга хэмжээ нэг бүрээр энэ журмын хавсралтын маягт 1-ийн дагуу боловсруулж, түүнд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ, хүчин чадал, төсөвт өртөг, худалдан авах ажиллагаанд мөрдөх журам, арга, хэрэгжүүлэх хугацаа болон холбогдох тайлбар, тодруулга зэрэг мэдээллийг тодорхой тусгана.

⁹ .Хуульд өөрөөр заагаагүй бол худалдан авах ажиллагааг зохион байгуулах, мэдээлэл солилцох, мэдээллийн ил тод байдлыг хангах ажиллагааг цахим системээр гүйцэтгэнэ.

¹⁰ 31.1.Захиалагч ерөнхий гэрээний аргаар худалдан авахаас бусад тохиолдолд хуульд заасан төсөвт өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын дараах аргын аль нэгийг дагуу зохион байгуулна:

Хүснэгт 2: Төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтын аргын тоон мэдээлэл
/сая. төгрөгөөр/

Төсөл арга хэмжээний ангилал	Төсөл арга хэмжээний тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тендер шалгаруулалтын арга									
				Нээлттэй тендер шалгаруулалт		Харьцуулалтын арга		Гэрээ шууд байгуулах		Нэг эх үүсвэрээс худалдан авах		Ерөнхий гэрээ	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Барилга, байгууламж	4	855.5	757.9	3	530					1	227.9		
Их засвар	18	3,822.20	2,799.9	7	2,063.2	8	604	3	132.7				
Тоног төхөөрөмж	14	891	891	2	440	8	393	3	50			1	8.0
Нийт дүн	36	5,568.70	4,448.8	12	3,033.2	16	997	6	182.7	1	227.9	1	8.0

Эх сурвалж : ХААГ-аас ирүүлсэн судалгаанаас

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны 30.5 хувийг нээлттэй тендер шалгаруулалтаар, 47.2 хувийг харьцуулалтын аргаар, 16 хувийг шууд худалдан авах аргаар, 0.02 хувийг ерөнхий гэрээний аргаар, 0.02 хувийг нэг эх үүсвэрээс худалдан авах аргаар тус тус зохион байгуулж 3 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаа амжилтгүй болсон байна. /Судалгааны хүснэгт-5/

Төсвийн Ерөнхийлөн захирагч орон нутгийн төсвийн хөрөнгөөр нийт 183.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр эрх шилжүүлснээс 5 төсөл арга хэмжээг өөрийн харьяаны бус байгууллагуудад шилжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 14.4¹¹-д заасантай бүрэн нийцээгүй байна. /Дэлгэрэнгүйг хүснэгтээс харах/

Хүснэгт 3: Эрх шилжүүлсэн ТАХ-ний мэдээлэл

/сая.төгрөгөөр/

№	Эрх шилжсэн төсөв захирагчийн ангилал		Төсөл арга хэмжээний нэр, хүчин чадал байршил	Батлагдсан төсөвт өртөг	Эрх шилжүүлсэн дүн	Худалдан авах ажиллагааны арга
	Нэр	Ангилал				
1	Бугат сум	Төсвийн төвлөрүүлэн захирагч	Иргэний танхимын сантехникийн засвар	20.00	20.00	Харьцуулалтын арга
2	Зэвсэгт хүчний 0234 дүгээр анги	Төсвийн шууд захирагч	Цэргийн албан хаагчдын орон сууцны засвар	45.00	45.00	Шууд худалдан авалт
3	Сайхан сум	Төсвийн төвлөрүүлэн захирагч	Наадмын талбайн засвар	60.00	60.00	Харьцуулалтын арга
4	Аймгийн Татварын хэлтэс	Төсвийн шууд захирагч	Тоног төхөөрөмж, техник хэрэгсэл	15.00	15.00	Шууд худалдан авалт
5	Эрүүл мэндийн даатгалын хэлтэс	Төсвийн шууд захирагч	Техник хэрэгсэл	8.00	8.00	Ерөнхий гэрээ
6	Нийгмийн даатгалын хэлтэс	Төсвийн шууд захирагч	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрүүл мэндийн үзлэгийн өрөөний тохижилт, тоног төхөөрөмж	15.00	15.00	Шууд худалдан авалт
7	Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар	Төсвийн шууд захирагч	Түр хамгаалах байрны тоног төхөөрөмж, тохижилт	20.00	19.80	Шууд худалдан авалт
Нийт дүн				183.00	182.80	

¹¹ 14.4.-д "Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсөв хуваарилах, зарцуулахтай холбогдсон бүрэн эрхээ төсвийн төвлөрүүлэн захирагч, эсхүл харьяалах төсвийн шууд захирагчид шилжүүлж болох бөгөөд ийнхүү шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй."

Эх сурвалж : ХААГ-аас ирүүлсэн судалгаанаас

Эрх шилжүүлсэн зарим төсөл арга хэмжээнээс төсвийн шууд захирагч нар худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа цахим системээр биш шууд худалдан авалт хийсэн нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 9.1¹², 41.1.1¹³-д заасантай нийцээгүй байна. Тухайлбал:

- Аймгийн Татварын газрын тоног төхөөрөмж, техник хэрэгсэл
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрүүл мэндийн үзлэгийн өрөөний тохижилт, тоног төхөөрөмж (Булган сум)
- Түр хамгаалах байрны тоног төхөөрөмж, тохижилт (Булган сум)

Энэ нь өрсөлдөөнийг хязгаарласан, нийтийн эрх ашиг зөрчигдөх, байгууллагын хэрэгцээ шаардлагад нийцээгүй тоног төхөөрөмж нийлүүлэгдэх эрсдэлтэй байгаад анхаарч цаашид дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай байгаад зөвлөмж хүргүүлээ.

2.2 Зарим хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичгийн техникийн тодорхойлолт холбогдох хуулийн заалттай нийцээгүй байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэчийг сонгон шалгаруулах “Үнэлгээний хороо”-г хуульд нийцүүлэн аймгийн Засаг даргын захирамжаар худалдан авах төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан байна.

Сангийн сайдын 2023 оны А/258, А/259, А/260, А/261 дүгээр “Тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг шинэчлэн батлах тухай” тушаалуудыг үндэслэн тендерийн баримт бичгийг боловсруулахаар зохицуулсан байдаг.

Дээрх тушаалуудаар батлагдсан жишиг баримт бичгүүдийг үндэслэн Үнэлгээний хороо нь төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичгийг боловсруулахдаа тендерт шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтэд ТБОНӨХБАҮХАТХ-ийн 7.1.10¹⁴-д заасан оролцогчийн ерөнхий шаардлагын магадлалыг тодорхой тусгаагүйгээс тендерт оролцогчид тендерийн бичиг баримтын маягтад тухайн заалттай холбоотой мэдэгдлийг ирүүлээгүй байна.

Мөн зарим төсөл арга хэмжээний техникийн тодорхойлолт нь ТБОНӨХБАҮХАТХ 12.3¹⁵12.4¹⁶, 12.5¹⁷-д заалттай нийцээгүй байна. Үүнд:

- ✚ Техникийн тодорхойлолтын шалгуур үзүүлэлтүүд нь хязгаарласан шинжтэй барааны тэмдэг, нэр, хэлбэр маяг, төрөл, гарал үүсэл, үйлдвэрлэлийн арга, үйлдвэрлэгч буюу нийлүүлэгчийг тухайлан заасан шаардлага, нөхцөлийг заах шаардлагатай бол түүний ард “эсхүл түүнтэй дүйцэх” гэсэн тодотгол хэрэглээгүй; (ХХААГ-ын суудлын машин)

¹² Хуульд өөрөөр заагаагүй бол худалдан авах ажиллагааг зохион байгуулах, мэдээлэл солилцох, мэдээллийн ил тод байдлыг хангах ажиллагааг цахим системээр гүйцэтгэнэ.

¹³ 41.1.1.энэ хуулийг зөрчиж гэрээ шууд байгуулсан;

¹⁴ Хүүхэд хамгааллын тухай хуулийн 30.4-т заасан хүүхэд хамгааллын бодлого батлаагүй хуулийн этгээд,

¹⁵ Хүүхэд хамгааллын тухай хуулийн 30.4-т заасан хүүхэд хамгааллын бодлого батлаагүй хуулийн этгээд,

¹⁶ Техникийн тодорхойлолтод тодорхой нэг аж ахуй эрхлэгчийн бараа, үйлчилгээний худалдааны нэр, патент, түүнийг эзэмшигч, үйлдвэрлэгч, нийлүүлэгч, эсхүл үйлдвэрлэлийн арга, гарал үүслийг тухайлан заахыг хориглоно.

¹⁷ Техникийн тодорхойлолтыг нарийвчлан тодорхойлох боломжгүй бол энэ тухай үндэслэл бүхий тайлбарыг дурдсаны үндсэн дээр зөвхөн тухайн бараанд холбогдуулан энэ хуулийн 12.4-т заасан шаардлага, нөхцөлийг тавьж болох бөгөөд энэ тохиолдолд “эсхүл түүнтэй дүйцэх” гэсэн тодотгол хэрэглэнэ.

- ✚ Өрсөлдөөнийг өрнүүлэх зарчмыг баримтлаагүй худалдан авах барааны шинж чанар, материал, үйл ажиллагааны шаардагдах стандартын талаар тодорхой тусгаагүй; (Стандарт хэмжил зүйн хэлтсийн суурин РН метрийн холбогдох үзүүлэлтийг тодорхойлоогүй)
- ✚ Шаардлагатай тохиолдолд батлагдсан төсөвт багтаан эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай хэрэглээний тогтвортой байдлыг хангах, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн байх үзүүлэлтийг тусгаж өгөөгүй. (Нийтлэг)

Энэ нь бараа бүтээгдэхүүнийг нийлүүлэгч чанаргүй бараа бүтээгдэхүүн нийлүүлэх, үүнтэй холбоотойгоор нэмэлт засвар үйлчилгээний зардал гарах, гомдол маргаан үүсэх эрсдэлтэй байна.

Иймд цаашид захиалагч техникийн тодорхойлолтыг боловсруулахдаа холбогдох хууль дүрэмд нийцэж байгаа эсэхэд хяналт хийж байх шаардлагатай байгаад зөвлөмж хүргүүлээ.

2.3 Холбогдох хууль, журам, тендерийн баримт бичигт тусгасан шаардлагыг хангасан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна.

ТБОНӨХБАҮХАТ хууль, Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”, 2023 оны 278 тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-д нийцүүлэн тендерийн баримт бичигт тусгагдсан шаардлагыг хангасан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна.

Худалдан авах ажиллагааны тендер сонгон шалгаруулахтай холбоотой дараах эрсдэлтэй асуудалд анхаарах шаардлагатай байна.

- Булган сумын Соёл амралтын цэцэрлэгт хүрээлэнгийн спорт тоглоомын барилгын засвар (Булган, Булган сум) төсөл, арга хэмжээний багц-1 тендерийн сонгон шалгаруулалтад оролцогчийн тендерийн үнийг мэргэшсэн төсөвчинөөр тооцож ирүүлсэн хэдий ч арифметик алдаатай ирүүлсэн,
- "Жаргалант" хүүхдийн зуслангийн захиргаа аж ахуй, гал тогооны барилгын тоног төхөөрөмжид тусгагдсан хөнжил техникийн тодорхойлолтод тусгагдсан үзүүлэлтийг хангасан гэх хангалттай бөгөөд зохистой нотолгоо байхгүй байна.

Тендер шалгаруулалттай холбоотой дээрх эрсдэлтэй асуудалд цаашид анхаарал хандуулж ТБОНӨХБАҮХАТ хуулийн 27.3¹⁸ дахь заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг хүргүүлээ.

3. Захиалагч нь тайлант онд хэрэгжих боломжгүй хугацаанд гэрээ байгуулснаас 2 төсөл, арга хэмжээ он дамжин хэрэгжих болсон.

3.1 Зарим төсөл, арга хэмжээний ажлын гүйцэтгэлд санхүүжилт олгохдоо журамд заасан баримт бичгийн бүрдлийг бүрэн бүрдүүлээгүй байна.

Тайлант онд ТЕЗ 4,275.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 31 төсөл, арга хэмжээнд 3,585.0 сая төгрөгийн санхүүжүүлэхээр аймгийн ИТХ-ын 2023 оны XIV/08 дугаар тогтоолоор баталсныг аймгийн ИТХ-ын 2024 оны XXV/05 дугаар тогтоолоор

¹⁸ Үнэлж байгаа тендерийн үнэд арифметик алдаа байвал захиалагч тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар залруулж, энэ тухай оролцогчид мэдэгдэж, хүлээн зөвшөөрөх эсэх талаар бичгээр хариу ирүүлэхийг шаардана.

тодотгон 5,450.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 44 төсөл, арга хэмжээнд 4,978.0 сая төгрөг зарцуулахаар баталж 4,731.5 сая төгрөгийн гэрээг байгуулан 3,658.3 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Хүснэгт 4: ОНХО-аар олгосон санхүүжилтийн мэдээлэл

/сая.төгрөгөөр/

ТАХ-ний ангилал	АИТХ-ын 2023.12.05-ны XIV/08 тогтоол			АИТХ-ын 2024.09.12-ны XXV/05 тогтоол /тодотголоор/					
	ТАХ тоо	Төсөвт өртөг	Батлагдсан санхүүжилт	ТАХ тоо	Төсөвт өртөг	Батлагдсан санхүүжилт	Гэрээний дүн	Санхүүжүүлсэн дүн	Үлдэгдэл санхүүжилт
Авто зам, дэд бүтэц	1	300.0	300.0	1	300.0	300.0	-	-	-
Барилга, байгууламж				5	625.5	527.9	564.3	406.2	156.4
Их засвар	17	3,154.0	2,464.0	16	3,258.5	2,883.5	3,130.0	2,320.2	805.2
Тоног төхөөрөмж, техник хэрэгсэл	13	821.0	821.0	22	1,266.6	1,266.6	1,037.2	931.9	105.3
Нийт дүн	31	4,275.0	3,585.0	44	5,450.6	4,978.0	4,731.5	3,658.3	1,066.9

Эх сурвалж : АИТХ-ын 2023 оны XIV/08, 2024 оны XXV/05 дугаар тогтоолоос

Төсөл, арга хэмжээний эхний болон явын санхүүжилтийг хяналт хэрэгжүүлсэн эрх бүхий албан тушаалтнуудын баталгаажуулсан ажлын гүйцэтгэл, ашиглагч байгууллагын тодорхойлолт, гүйцэтгэгчийн хүсэлтийг үндэслэн гэрээний тусгай нөхцөлд заасны дагуу 30.0-80.0 хувиар тооцож, гүйцэтгэгч компаниудад олгосон байна.

Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 249 дүгээр тогтоолыг үндэслэн он дамжин хэрэгжихээр гэрээ байгуулсан болон гэрээний хугацаанд ашиглалтад хүлээлгэж өгөөгүй төсөл, арга хэмжээнүүдийн санхүүжилт болох нийт 189.0 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын барьцаа дансанд байршуулсан байна.

Дээрх төсөл, арга хэмжээнд санхүүжилт олгохдоо ЗГ-ын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.3-т заасантай нийцээгүй байна. Тухайлбал:

- ✚ Үнэлгээний хороо байгуулсан шийдвэр, үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл,
- ✚ Захиалагчийн хянан баталгаажуулсан ил далд ажлын акт, ажлын гүйцэтгэлийг нотолсон гэрэл зураг,
- ✚ Байнгын ашиглалтад хүлээн авах комиссын хурлын тэмдэглэл, үүрэг даалгаврын биелэлт,
- ✚ Байнгын ашиглалтад хүлээн авсан улсын комиссын акт зэрэг төсөл, арга хэмжээний санхүүжилт олгох баримт бичгийн бүрдэл дутуу байна.

ЗГ-ын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.3.12.1¹⁹-д заасны дагуу Зам тээврийн яамны дансанд нормчлолын зардлыг төвлөрүүлсэн баримтыг гүйцэтгэгчээс авч баримтжуулаагүй байгаад зөвлөмж хүргүүлээ.

¹⁹ авто замын төсөл, арга хэмжээний хувьд Авто замын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу авто замын барилга, засвар, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийн ажлын төсөвт өртөгийн 0.4 хувиас хэтрэхгүй байхаар тооцож гэрээнд тусгах,

“Аймгийн нөөцийн тэжээлийн агуулахын засвар, тохижилт (Булган сум)” төсөл арга хэмжээг 2024 оны 05 дугаар сарын 05-ны дотор гүйцэтгэх гэрээгээр “Сэмэ” ХХК-аар гүйцэтгүүлсэн байна. Төсөл, арга хэмжээний зураг, төсвийг захиалагчийн хяналт, зохиогчийн хяналт болон чанарын хяналтын нийт 2.4 сая төгрөгийг аж ахуй нэгж рүү шилжүүлсэн зөрчилд төлбөрийн акт тогтоов.

3.2 Зарим хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Захиалагч тайлант онд шинээр эхлэх 39 төсөл, арга хэмжээнээс 31 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр нийт 3,881.8 сая төгрөгийн гэрээ байгуулсан байна. (Дэлгэрэнгүйг Судалгаа 3-т харуулав)

Тухайн онд хэрэгжиж дуусахаар төлөвлөсөн “0.4 КВТ цахилгаан дамжуулах шугамын ажлын санхүүжилт (Баян-Агт сум)” болон “Усан шүүлтүүртэй халаалтын тогоо шинэчлэх 1,8мвт (Хутаг-Өндөр сум)” төсөл, арга хэмжээг хэрэгжих боломжгүй хугацаанд буюу 11, 12 дугаар сард гэрээ байгуулж, он дамжин хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1 дэх “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулахад дараах журмыг баримтална.”, 13.1.4:“төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд гэрээ байгуулах шийдвэр гаргахгүй байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталж төлөвлөсөн ч хэрэгжээгүй 11 төсөл, арга хэмжээ байна. Тус төсөл, арга хэмжээ нь дараах шалтгааны улмаас хэрэгжээгүй байна. Үүнд:

- ✚ Тендерт оролцогч оролцохгүй байх,
- ✚ Тендерийг олон /3-9/ удаа зарласан ч амжилтгүй болох,
- ✚ Магадлалын ерөнхий дүгнэлтгүй, тоног төхөөрөмж нийлүүлэх, техникийн тодорхойлолт, ажлын даалгаваргүй
- ✚ ТЭЗҮ-гүй төсөл, арга хэмжээг хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр батлах,
- ✚ ТЭЗҮ-гүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталснаас төсөвт өртөг хүрэхгүй байх,
- ✚ Зарим тендерт оролцогч шалгараагүйгээс олон удаа зарлах, оны сүүлд гэрээг хийх, гэрээ хийсэн ч гүйцэтгэл гарахгүй байх

гэх мэт шалтгаанаар төсөл, арга хэмжээ төлөвлөгдсөн хугацаанд хэрэгжээгүй байна.

ТЕЗ-ийн орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнээс гэрээний хугацаанд зарим бараа, ажил үйлчилгээг хүлээлгэн өгөөгүй байна. Тухайлбал:

1. Булган сумын Соёл амралтын цэцэрлэгт хүрээлэнгийн спорт тоглоомын барилгын засвар (Булган, Булган сум),
2. Нэгдсэн эмнэлгийн гадна зам талбайн засвар, арчлалт,
3. Махны хөргүүртэй зоорины дутуу санхүүжилт (2010 онд гэрээ байгуулж 2017 онд хүлээлгэн өгсөн),

Дээрх төсөл, арга хэмжээг гэрээний хугацаанд биелүүлээгүйд 4.3 сая төгрөгийн алдангийг тооцож гүйцэтгэгчийн санхүүжилтээс суутган авсан байна.

3.3 Бүрэн хэрэгжсэн зарим хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг техникийн тодорхойлолт, ажлын тоо хэмжээ, материалын дагуу хүлээж аваагүй байна.

Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын зарим төсөл, арга хэмжээг техникийн тодорхойлолтын дагуу хүлээж аваагүй байна. Тухайлбал:

- ✚ “Драйгер баталгаажуулах болон пестицид тодорхойлох эталон тоног төхөөрөмж”-ийн техникийн тодорхойлолтод пестицидийн гаргасан үр дүн мэдээллийг агуулах суурин компьютер *Generation Intel Core i5* үзүүлэлтийг хангасан байхаар тусгасан ч *Generation Intel Core i3*,
- ✚ “Ахмадын амралт, сувиллын эмчилгээ сувилгааны тоног төхөөрөмж”-ийн санал болгож буй техникийн тодорхойлолтод БНСУ-д үйлдвэрлэгдсэн “*CereGem V3*” загварын хаш чулуун ор нийлүүлэхээр техникийн тодорхойлолтод туссан ч БНХАЯУ-ын “*Chigo*” загварын ор хүлээж авсан,
- ✚ “Сургуулийн барилгын засвар (Хишиг-Өндөр сум)”-ийн ажлын төсөвт тусгагдсан дараах ажил бүрэн хийгдээгүй байна.

№	Засварын ажлын төсөв	Гүйцэтгэлээр
1	Вакум цонх угсрах-3 давхар шилтэй	Вакум цонх угсрах-2 давхар шилтэй
2	Цонхонд өнгөлсөн гантиг тавиур суулгах	Цонхонд хуванцар тавиур суулгасан
3	Цонхны ус хаялга төмөрлөх	нийцээгүй
4	Эмультсээр хана будах	нийцээгүй
5	Бетоны дэвсгэр үе хийх шалны тэгшилгээ ба тусгаарлалт хийх	шаардлага хангаагүй
6	20 мм зузаан цементэн тэгшилгээ хийх	шаардлага хангаагүй
7	Шаланд хулдаас /LG/ наах	LG хулдаас биш чанарын шаардлага хангаагүй хулдаас
8	Замаск	Хийгээгүй
9	Зүлгүүр	Хийгээгүй

Дээрх техникийн тодорхойлолт, ажлын тоо хэмжээ, материалын дагуу хүлээж аваагүй нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.10.1.5²⁰ хуулийн заалттай нийцээгүй байна.

Мөн “Музейн барилгын засвар” төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж 2024 оны 08 дугаар сард хүлээн авч ашиглалтад оруулсан ч 2025 оны 05 дугаар сарын байдлаар шаланд цууралт үүссэн, сараалжин дүүжин таазны залгаа зөрсөн, холбож наасан лент тасарсан, “Аймгийн Засаг даргын тамгын газрын барилгын дээврийн засвар”-ын ажлын хүрээнд хийгдсэн ус зайлуулах налууг дутуу хийсэн байна.

Дээрх зөрчлийн хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр шийдвэрлэв. Үүнд:

- “Ахмадын амралт, сувиллын эмчилгээ сувилгааны тоног төхөөрөмж”-ийн санал болгож буй техникийн тодорхойлолтоос зөрүүтэй хаш чулуун орны үнийн зөрүүгээр төлбөрийн акт тогтоох,

²⁰ захиалагч нь худалдан авсан тоног төхөөрөмжийг комисс байгуулах замаар бүрэн бүтэн байдал, чанарын баталгаа, иж бүрдэл зэргийг бүрэн хэмжээгээр шалгаж хүлээж авах бөгөөд хүлээн авах комисс томилсон шийдвэр, комиссын гишүүдийн саналын хуудас, хурлын тэмдэглэл, энэ журмын 9 болон 13 дугаар хавсралтад заасан маягтын дагуу тоног төхөөрөмж хүлээн авсан акт зэргийг үйлдэж санхүүжилтийн баримт бичгийн иж бүрдэлд хавсаргана;

- “Драйгер баталгаажуулах болон пестицид тодорхойлох эталон тоног төхөөрөмж”-ийн техникийн тодорхойлолтод пестицидийн гаргасан үр дүн мэдээллийг агуулах суурин компьютерын үзүүлэлтийг техникийн тодорхойлолтод нийцүүлж, төсвийг хохиролгүй болгох хугацаатай албан шаардлага,
- “Музейн барилгын засвар”, “Аймгийн Засаг даргын тамгын газрын барилгын дээврийн засвар”-ын ажлын эвдрэл, гэмтлийг засах, сайжруулах, дутуу ажлыг гүйцэтгүүлэх хугацаатай албан шаардлага,
- “Сургуулийн барилгын засвар (Хишиг-Өндөр сум)”-ийн ажлын төсөвт тусгагдсан ажлын гүйцэтгэл зөрүүтэйг арилгах хугацаатай албан шаардлага тогтоон холбогдох байгууллагуудад /ХХҮГ, СХЗХ, ГХБХБГ/ үүрэг болгохоор шийдвэрлэлээ.

3.4 Хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийг бүртгэл тайланд бүрэн тусгаагүй байна.

Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтаар авто зам дэд бүтцийн 1, барилга байгууламж 5, их засвар 22, тоног төхөөрөмж 16 нийт 44 төсөл арга хэмжээнээс 32 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжсэн ч 62.5 хувь буюу 20 төсөл арга хэмжээний үр дүнд хөрөнгийг бүртгэл тайланд тусгасан байна. /Дэлгэрэнгүйг хавсралт 1-ээс харна уу/

Хүснэгт 5: Бүрэн хэрэгжсэн ТАХ-ээс бүртгэлд тусгасан ТАХ

/сая.төгрөгөөр/						
Төсөл, арга хэмжээний ангилал	Төсөвт өртөг	ТАХ-ний тоо	Гэрээний дүн	ТАХ-ний тоо	Бүртгэлд тусгасан дүн	ТАХ-ний тоо
Барилга байгууламж	180.00	1	179.8	1		
Их засвар	3200.75	18	3,318.3	18	1,973.9	10
Тоног, төхөөрөмж	749.70	13	743.7	13	564.2	10
Нийт	4130.45	32	4,241.8	32	2,538.1	20

Эх сурвалж : СТСХ-ээс ирүүлсэн судалгаанаас

Бүрэн хэрэгжсэн 1,636.8 сая төгрөгийн 12 төсөл арга хэмжээ, он дамжин хэрэгжих 325.5 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээ тайлан бүртгэлд тусгагдаагүй байна.

Хүснэгт 6: Бүртгэлд тусгасан ТАХ /Эрх зүйн шийдвэрээр/

/сая.төгрөгөөр/							
Төсөл, арга хэмжээний ангилал/ тоо		Төсөвт өртөг	Гэрээний дүн	Бүртгэлд тусгасан		Бүртгэлд тусгаагүй	
				ТАХ-ний тоо	Мөнгөн дүн	ТАХ-ний тоо	Мөнгөн дүн
Бүртгэлд тусгах шийдвэртэй	Их засвар	4	1,159.0	793.5			
	Барилга байгууламж	1	180.0	179.8	0	0	179.8
	Нийт	5	1,339.0	973.3	3	729.9	
Бүртгэлд тусгах шийдвэргүй	Их засвар	7	1,151.0	1,305.9	7	1,244.0	
	Тоног, төхөөрөмж	10	603.0	599.7	10	564.2	
	Нийт	17	1,754.0	1,905.6	17	1,808.2	
Нийт дүн		22	3,093.0	2,878.9	20	2,538.1	273.9

Эх сурвалж : СТСХ-ээс ирүүлсэн судалгаанаас

Аудитын хүрээнд Орон нутгийн өмчийн газраас ирүүлсэн 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 141 тоот албан бичгийн хавсралт баримтаар Засаг даргын

2025 оны 01 дүгээр сарын 10-ны А/21, мөн оны 02 дугаар сарын 03-ны А/66 дугаар захирамжаар 5 төсөл арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийг байнгын ашиглагч байгууллага бүртгэлд тусгах захирамж гаргажээ.

Захирамжид тусгагдсан Эрүүл мэндийн төвийн засвар (Хутаг-Өндөр сум) болон Усан сан, цэвэр усны шугамын шинэчлэлийн ажлын үргэлжлэл (Сэлэнгэ сум) төсөл арга хэмжээг байнгын ашиглагч байгууллага бүртгэлд тусгаагүй байна.

Дээрх 5 төсөл арга хэмжээнээс бусад бүрэн хэрэгжсэн 17 төсөл арга хэмжээний 1,754.0 сая төгрөгийн хөрөнгийг хөрөнгө бүртгэх шийдвэргүйгээр байнгын ашиглагч байгууллага бүртгэл, тайланд тусгажээ.

Дээрх хүснэгт 1, 2-т дурдсан төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон эд хөрөнгийг бүртгэлд тусгаагүй, ТЭЗ-аас гэрээ хийх захирамжид заасны дагуу тухайн байгууллага хүлээн авч буй нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4²¹, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.2²², ТБОНӨХБАҮХАТ хуулийн 6 дугаар зүйлийн 6.2²³, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.1²⁴, ТӨБЗГ-ийн 2019 оны 217 дүгээр тогтоолын 5 болон Булган аймгийн ЗД-ын 2020 оны А/424 дүгээр захирамжаар баталгаажсан НБББББ-ийн 4.6²⁵, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 5.4.4²⁶, 5.4.5²⁷, 5.5.1²⁸, 5.5.2²⁹, 5.5.3³⁰ дахь заалттай нийцээгүй байна.

Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалт дээрх хууль, тогтоомж, эрх зүйн актын холбогдох заалттай нийцээгүй нь:

 ОНХО-ын санхүүгийн тайланг НБББББ-ийн 4.6-д заасны дагуу тайлагнаагүй,

²¹ Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсөв хуваарилах, зарцуулахтай холбогдсон бүрэн эрхээ төсвийн төвлөрүүлэн захирагч, эсхүл **харьяалах төсвийн шууд** захирагчид шилжүүлж болох бөгөөд ийнхүү шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

²² бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага,

²³ Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна. Төсөвт авсан зээл, хандив, дэмжлэг, тусламжаар бий болсон хөрөнгө үүнд нэгэн адил хамаарна

²⁴ иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас олгосон эрх хэмжээний дотор орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах;

²⁵ Орон нутгийн хөрөнгө оруулалт

²⁶ 5.4.4.Захиалагч байгууллага нь барилга байгууламж болон их засварын ажлын хувьд уг ажлыг дуусах хүртэл хугацаанд, тоног төхөөрөмжийн хувьд хүлээн авсан эцсийн гүйцэтгэлийн дүнгээр бусад **эргэлтийн хөрөнгөөр** тус тус бүртгэн **санхүүгийн тайландаа** тусгана;

²⁷ 5.4.5.Захиалагч байгууллага нь их засварын ажлын зардлыг засварын ажлыг хүлээлгэн өгсөн актыг үндэслэн зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэнэ;

²⁸ 5.5.1.Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу төрийн болон **орон нутгийн өмч байх** буюу төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг байнгын ашиглалтад хүлээн авсан, тоног төхөөрөмж хүлээн авсан акт болон зураг төсөл, ТЭЗҮ-г захиалагч хүлээн авсны дараа төрийн болон орон нутгийн өмчид бүртгүүлнэ;

²⁹ 5.5.3.Энэ журмын 5.5.1-д заасан хөрөнгийг төрийн болон орон нутгийн өмчид бүртгүүлэх чиг үүргийг захиалагчийн **өмчийн асуудал хариуцсан нэгж (ажилтан) хэрэгжүүлэх** бөгөөд өмчид бүртгүүлэхийг **тодорхойлох** урьдчилсан маягтыг бөглөн цахим системээр гүйцэтгэлийн санхүүжилтийн хүсэлтэд хамт ирүүлж, цахим системийн өмчийн санд мэдээллийн санг бүрдүүлнэ;

³⁰ 5.5.3.Өмчийн эцсийн өмчлөгчийг тодорхойлсон шийдвэрийн дагуу төрийн өмчийн бүртгэлийн нэгдсэн системд өмчийн бүртгэл хийгдсэнээр цахим систем дэх урьдчилсан бүртгэлийн мэдээлэл баталгаажиж өмчийн мэдээллийн санд бүртгэгдэнэ.

- ✚ ТЕЗ төсвийн тухай хуулийн 14.4-т заасныг зөрчин төсөл, арга хэмжээг хариуцан хэрэгжүүлэх эрхийг өөрийн харьяаны бус төсвийн захирагчид шилжүүлсэн,
- ✚ ОНХО-ын төсөл, арга хэмжээг гүйцэтгэгчтэй хийх гэрээ байгуулах эрх олгосон захирамжид төсөл, арга хэмжээний үр дүнд бий болох эд хөрөнгийг тухайн байгууллага хүлээж авахаар тусгадаг,
- ✚ Бүрэн хэрэгжсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгө, засварыг байнгын ашиглагч байгууллагуудад шилжүүлсэн шийдвэрийг бүрэн гаргаагүй,
- ✚ ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын салбар дундын хамтын ажиллагаа уялдаа сул, хангалтгүй

зэргээс ОНХО-аас санхүүжин хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний үр дүнд бий болох эд хөрөнгийг бүртгэл тайланд тусгагдахгүй орхигдох, эзэнгүйдэх эрсдэл үүсэж байна.

Байнгын ашиглагч байгууллагыг тодорхойлж эрх зүйн шийдвэр гарган бүртгэлд тусгагдаагүй хөрөнгийг бүртгэлд авах зөрчлийг арилгах хугацаатай албан шаардлага хүргүүлээ.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Дунд болон богино хугацааны хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг, аргачлалын дагуу үнэлж эрэмбэлэн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцоогүй, хуульд заасан техник, эдийн засгийн үндэслэл, батлагдсан зураг төсвийн шаардлага хангагдаагүй зарим шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.
2. Төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль журамд нийцүүлэн худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.
3. Эрх шилжүүлсэн зарим хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу цахимаар зохион байгуулаагүй шууд худалдан авалт хийсэн байна,
4. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн санхүүжилт олгохдоо ЗГ-ын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.3-т заасан баримт бичгийн бүрдлийг цаасаар бүрэн бүрдүүлээгүй байна.
5. Зарим төсөл, арга хэмжээг техникийн тодорхойлолтын дагуу хүлээж аваагүй байна.
6. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг хууль, журам, НБББББ-т тусгасны дагуу хөтөлдөггүй,
7. ТЕЗ-ийн харьяаны бус төсвийн шууд захирагчид төсөл, арга хэмжээний эрхийг шилжүүлсэн,
8. Төсөл арга хэмжээний үр дүнд бий болсон эд хөрөнгийн байнгын ашиглагчийг бүрэн тодорхойлдоггүй, бүртгэлд тусгах эрх зүйн шийдвэрийг бүрэн гаргадаггүй,

9. ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын хамтын ажиллагаа хангалтгүйгээс төсөл арга хэмжээний баримтын бүрдэл, эрх зүйн шийдвэр болон эд хөрөнгийн бүртгэл дутуу хийгдсэн байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Ж.Ганболд танаа:

1. Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.42 -т заасны дагуу техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвийг батлуулсан байх шаардлагыг хангасан төсөл, арга хэмжээг хэлэлцүүлэн батлах,

Аймгийн Засаг дарга Д.Пүрэв-Очир танаа:

1. Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө хууль, эрх зүйн холбогдох шаардлагад нийцүүлэн төлөвлөх, төлөвлөлтөд тавих хяналтыг сайжруулах.
2. Цаашид хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл арга хэмжээний техникийн тодорхойлолтыг холбогдох хуулийн заалттай нийцүүлэн төлөвлөж хяналтыг сайжруулах.
3. Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 5.4.4, 5.4.5, 5.5.2, 5.5.3 дахь заалтыг мөрдөн ажиллах,
4. ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын хамтын ажиллагаа, эрх үүргийн уялдааг хангах тал дээр анхаарал хандуулж, салбар дундын хамтын ажиллагааны процессын уялдааг хангах уулзалт зохион байгуулж ажиллах,

Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга Б.Ариунболд танаа:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг НБББББ-ын 4.6, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 5.4.4, 5.4.5, 5.5.1-д заасны дагуу хөтлөх,
2. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн санхүүжилт олгохдоо ЗГ-ын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.3-т заасан баримт бичгийн бүрдлийг цаасаар бүрэн бүрдүүлэх.

Худалдан авах ажиллагааны газрын дарга Б.Баярцэнгэл танаа:

1. Хөрөнгө оруулалтаар эрх шилжсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хэрхэн зохион байгуулах, шалгаруулах сургалтыг холбогдох байгууллагуудад зохион байгуулах, цаашид захиалагчийн техникийн тодорхойлолтыг боловсруулахдаа холбогдох хууль дүрэмд нийцэж байгаа эсэхэд хяналт хийж байх,

2. ТБОНӨХБАҮХАТ хуулийн 27.3³¹ дахь заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах

Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Т.Баттулга танаа:

1. Аймгийн Засаг даргын 2023 оны А/764 дүгээр захирамжаар батлагдсан “аймгийн орон нутгийн өмчийн газрын дүрэм”-ын 2.1-д заасан хяналтыг сайжруулах, 2.3.3, 2.3.6, 2.3.10-д заасан журмын төслийг бэлтгэх, эрх бүхий этгээдээр батлуулах,

-oOo-

³¹ Үнэлж байгаа тендерийн үнэд арифметик алдаа байвал захиалагч тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар залруулж, энэ тухай оролцогчид мэдэгдэж, хүлээн зөвшөөрөх эсэх талаар бичгээр хариу ирүүлэхийг шаардана.



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2025 оны 08 сарын 03 өдөр

Дугаар 0/11

Булган сум

┌ Аудитын тайлан баталгаажуулах тухай ┐

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 10 дугаар зүйл, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам" 2020 оны А/106 дугаар тушаалын 18.9, "Эрх шилжүүлэх тухай" 2023 оны А/102 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтын 1.4-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1 "Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт"-д хийсэн нийцлийн аудитын тайланг нэгдүгээр, аудитын зөрчлийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.

2.Аудитын тайланг Нийслэл дэх Төрийн аудитын газар, Булган аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт тус тус хүргүүлэхийг ахлах аудитор (Г.Намчинсүрэн)-д үүрэг болгосугай.

3.Аудиттай холбоотой ажлын баримт, нотлох баримтыг архивын нэгж болгон хүлээлгэн өгөх, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор (Г.Намчинсүрэн)-д даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТЦОГТ

632501018

Хавсралт 1

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2024 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ

/сая.төгрөгөөг/

№	Төсөл, арга хэмжээний нэр	Шинэ, шилжих	Хугацаа		Төсөл, арга хэмжээний ангилал	Төсөвт өртөг	Гүйцэтгэгчийн нэр	Гэрээний дүн*	Хэрэгжиж дууссан ТАХ		Он дамжин хэрэгжиж байгаа болон хэрэгжилт дутуу ТАХ		Хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийн бүртгэл				Тайлбар
			Эхлэх	Дуусах					/тийм, үгүй/	/тийм, үгүй/	Ажлын гүйцэтгэлийн хувь	Бүртгэлд тусгах шийдвэр	Ашиглагч байгууллагын нэр	Бүртгэсэн эсэх /тийм, үгүй/	Бүртгэлд тусгасан дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	
1	Биеийн тамир спортын газрын "Б" заалны их засвар	Шилжих	2023	2024	Их засвар	250.0	Эпо ХХК	242.0	тийм	Үгүй			БТСГ	тийм	241.96	Биеийн тамир спортын газрын данс бүртгэлд бүртгэсэн	
2	Соёлын төвийн барилгын их засвар (Орхон сум)	Шинэ	2024	2024	Их засвар	450.0	Гурван уулын хишиг ХХК	524.0	тийм	Үгүй			Орхон сумын Соёлын төв	тийм	561.80	Орхон сумын Соёлын төвийн данс бүртгэлд бүртгэсэн	
3	Аймгийн нөөцийн тэжээлийн агуулахын засвар, тохижилт (Булган сум)	Шинэ	2024	2024	Их засвар	30.0	Сэмэ ХХК	29.1	тийм	Үгүй			ХАА-н хөгжлийн ирээдүй	тийм	29.10	Хөдөө-аж ахуй-Хөгжлийн ирээдүй ОНӨХХК-ийн данс бүртгэлд бүртгэсэн	
4	Аймгийн Засаг даргын тамгын газрын барилгын дээврийн засвар	Шинэ	2024	2024	Их засвар	235.5	Сэнгүн констракшн ХХК	226.3	тийм	Үгүй			Аймгийн ЗДТГ	тийм	226.30	Аймгийн ЗДТГ-ын данс бүртгэлд бүтгэсэн	
5	Иргэний танхимын сантехникийн засвар (Бугат сум)	Шинэ	2024	2024	Их засвар	20.0	Баялаг тамир ХХК	20.0	тийм	Үгүй			Бугат ЗДТГ	тийм	20.00	Бугат сумын ЗДТГ	
6	Сургуулийн барилгын засвар (Хишиг-Өндөр сум)	Шинэ	2024	2024	Их засвар	150.0	Туст эр констракшн ХХК	249.0	тийм	Үгүй			Хишиг-Өндөр сумын ЕБС	тийм	149.30	Хишиг-Өндөр сумын ЕБС-ийн данс бүртгэлд бүртгэсэн	
7	Соёлын төвийн барилгын их засварын үлдэгдэл санхүүжилт (Баяннуур сум)	Шилжих	2022	2023	Их засвар	15.5	Густокөк ХХК	15.5	тийм	Үгүй			Баяннуур сумын Соёлын төв	тийм	15.50	2023 онд данс бүртгэлд тусгасан	

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2024 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

8	Аймгийн татварын хэлтсийн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл	Шинэ	2024	2024	Тоног, төхөөрөмж	15.0	Санбум ХХК	14.9	тийм	Үгүй	Аймгийн татварын хэлтэс	Тийм	14.90	Данс бүртгэлд бүртгэсэн
9	Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн техник хэрэгсэл	Шинэ	2024	2024	Тоног, төхөөрөмж	8.0	Ай Ти Зон ХХК	8.0	тийм	Үгүй	Эрүүл мэндийн даатгал	Тийм	8.00	Данс бүртгэлд бүртгэсэн
10	"Жаргалант" хүүхдийн зуслангийн захиргаа аж ахуй, гал тогооны барилгын тоног төхөөрөмж	Шинэ	2024	2024	Тоног, төхөөрөмж	75.0	Дансран дүвчин ХХК	73.9	тийм	Үгүй	Жаргалант зуслан	Тийм	73.90	Данс бүртгэлд бүртгэсэн
11	Драйгер баталгаажуулах болон пестицид тодорхойлох эталон тоног төхөөрөмж	Шинэ	2024	2024	Тоног, төхөөрөмж	25.0	Пи Эс Си Грийн химистри ХХК	7.9	тийм	Үгүй	Стандарт хэмжилзүйн хэлтэс	Тийм	7.90	Данс бүртгэлд бүртгэсэн
							Арьяма юнайтед ХХК	10.0					10.00	Данс бүртгэлд бүртгэсэн
							Тэбаса ХХК	7.1					7.10	Данс бүртгэлд бүртгэсэн
12	Санхүүгийн хяналт, дотоод аудитын автомашин	Шинэ	2024	2024	Тоног, төхөөрөмж	50.0	Тэбаса ХХК	49.5	тийм	Үгүй	Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба	Тийм	49.50	Данс бүртгэлд бүртгэсэн
13	Ахмадын сувиллын сувилгааны төхөөрөмж	Шинэ	2024	2024	Тоног, төхөөрөмж	25.0	Санаа мед трейд ХХК	24.0	тийм	Үгүй	ХХҮГазар	Тийм	24.00	Данс бүртгэлд бүртгэсэн
14	Соёлын үйлчилгээг үзүүлэхэд шаардагдах автомашин (Булган сумын Соёлын ордон)	Шинэ	2024	2024	Тоног, төхөөрөмж	50.0	Дансран дүвчин ХХК	49.9	тийм	Үгүй	(Булган сумын Соёлын ордон)	Тийм	49.90	Данс бүртгэлд бүртгэсэн
15	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрүүл мэндийн үзлэгийн өрөөний тохижилт, тоног төхөөрөмж (Булган сум)	Шинэ	2024	2024	Тоног, төхөөрөмж	15.0	РС молл, Хантүм глобал ХХК	15.0	тийм	Үгүй	Нийгмийн даатгалын хэлтэс	тийм	15.00	Данс бүртгэлд бүртгэсэн
16	Түр хамгаалах байрны тоног төхөөрөмж, тохижилт (Булган сум)	Шинэ	2024	2024	Тоног, төхөөрөмж	20.0	Хурмастыг хүлэг ХХК	19.8	тийм	Үгүй	ГБХЗХГазар	Тийм	19.80	Данс бүртгэлд бүртгэсэн
17	ЕБС-ийн цахим танхим тохижуулах (Бугат, Сэлэнгэ, Баян-Агт, Сайхан сумын Ерөнхий боловсролын сургууль)	Шинэ	2024	2024	Тоног, төхөөрөмж	320.0	МВМ СОР ХХК	319.8	тийм	Үгүй	ЕБС-ийн цахим танхим тохижуулах (Бугат, Сэлэнгэ, Баян-Агт, Сайхан сумын Ерөнхий боловсролын сургууль)	Тийм	284.20	Данс бүртгэлд бүртгэсэн

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2024 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

18	Нэгдсэн эмнэлгийн гадна зам талбайн засвар, арчлалт	Шинэ	2024	2024	Их засвар	150.0	Энх алтаргана ХХК	142.4	тийм	Үгүй	ЗД-ын 2025.01.10 А/21	Нэгдсэн эмнэлэг	тийм	142.80	Нэгдсэн эмнэлгийн бүртгэлд бүтгэсэн	данс
19	Музейн барилгын засвар	Шинэ	2024	2025	Их засвар	359.0	Соотон Чоно ХХК	359.0	тийм	Үгүй	ЗД-ын 2025.01.10 А/21	Музей	тийм	389.00	Музейн бүртгэсэн	данс бүртгэлд
20	Булган сумын Соёл амралтын цэцэрлэгт хүрээлэнгийн спорт тоглоомын барилгын засвар (Булган, Булган сум)	Шинэ	2024	2024	Их засвар	550.0	Өвөлжөөн булаг ХХК	198.0	тийм	Үгүй	ЗД-ын 2025.02.03 А/66	Тохижилт үйлчилгээний анги	тийм	198.10	Тохижилт үйлчилгээний данс бүртгэсэн	ангийн
							Соотон чоно ХХК	340.0	тийм	Үгүй			үгүй		Бүртгэлд тусгаагүй	
21	Эрүүл мэндийн төвийн засвар (Хутаг-Өндөр сум)	Шинэ	2024	2024	Их засвар	100.0	Ланд арч ХХК	94.1	тийм	Үгүй	ЗД-ын 2025.02.03 А/66	Хутаг-Өндөр сумын ЭМТ	үгүй		Бүртгэлд тусгаагүй	
22	Усан сан, цэвэр усны шугамын шинэчлэлийн ажлын үргэлжлэл (Сэлэнгэ сум)	Шинэ	2024	2024	Барилга байгууламж	180.0	Баатар шүтээн уул ХХК	179.8	тийм	Үгүй	ЗД-ын 2025.01.10 А/21	Сэлэнгэ сумын ЗДТГ	үгүй		Бүртгэлд тусгаагүй	
23	18 дугаар байр хүртэлх чиглэлийн шугамын шинэчлэл (Булган сум)	Шилжих	2023	2024	Их засвар	360.0	Багандант ХХК	358.5	тийм	Үгүй			үгүй			
24	Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн дотуур байрны цэвэр, бохир усны шугамын шинэчлэл (Булган сум)	Шинэ	2024	2024	Их засвар	78.0	Булган Мээж ХХК	78.0	тийм	Үгүй			үгүй		Тушаал шийдвэр хүлээж байгаа. Ашиглалтад орсон	
25	Төрийн албан хаагчийн байрны засвар (Баяннуур сум)	Шинэ	2024	2025	Их засвар	250.0	Соотон Чоно ХХК	240.5	тийм	Үгүй			үгүй		Засвар хийгдээд дууссан ч хүлээж аваагүй байна	
26	Авто тээврийн үндэсний төвийн Булган салбарын барилгын засвар	Шинэ	2024	2024	Их засвар	30.0	Гурван уулын хишиг ХХК	29.1	тийм	Үгүй			үгүй		Төрийн өмчийн зохицуулалтын шийдвэр гараагүй	бодлого газраас
27	Цэргийн албан хаагчдын орон сууцны засвар (Зэвсэгт хүчний 0234 дүгээр анги)	Шинэ	2024	2024	Их засвар	45.0	ЗХ-ний 234 дүгээр анги	45.0	тийм	Үгүй			үгүй		Жанжин штабаас хүлээж байгаа	тушаал

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2024 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

28	Наадмын талбайн засвар (Сайхан сум)	Шинэ	2024	2024	Их засвар	60.0	И ЭС БИ АЙ ХХК	60.0		тийм	Үгүй	үгүй	Данс бүртгэлд тусгаагүй, улсын комисс хүлээж аваагүй 20 сая санхүүжилт аваагүй дутуу.
29	Хөгжимт жүжгийн театрын гадна дулаан, сантехникийн ажил (аймгийн Онцгой комиссын шийдвэрээр засварласан)	Шинэ	2024	2024	Их засвар	67.7	Булган Мээж ХХК	67.7		тийм	Үгүй	үгүй	Бүртгэлд тусгаагүй
30	Хүнс, хөдөө аж ахуйн газрын суудлын автомашин	Шинэ	2024	2024	Тоног, төхөөрөмж	28.0	Өвөлжөөн булаг ХХК	27.3		тийм	Үгүй	үгүй	Бүртгэлд тусгаагүй
31	Шуурхай мэдээллийн төвийн тоног төхөөрөмж (Булган сум)	Шинэ	2024	2024	Тоног, төхөөрөмж	100.0	Монтех дистрибьюшн	98.0		тийм	Үгүй	үгүй	Бүртгэлд тусгаагүй
32	Махны хөргүүртэй зоорьны дутуу санхүүжилт (2010 онд гэрээ байгуулж 2017 онд хүлээлгэн өгсөн)	Шилжих	2010	2017	Тоног, төхөөрөмж	18.7	Агар фүүд ХХК	18.7		тийм	Үгүй	үгүй	Аймгийн ИТХ-ын хурлаар данс бүртгэлд тусгах шийдвэр гарна.
Хэрэгжсэн ТАХ-ний дүн						4,130.4	35	4,241.8	2,538.1				
33	Булган аймаг дахь Тагнуулын хэлтсийн алба хаагчдын орон сууцны төлбөр (2 ш орон сууц, 49.67 м2, 58.87м2)	Шинэ	2024	2024	Барилга байгууламж	325.5	Хишиг дулаан ХХК	325.5	70%	үгүй	тийм	үгүй	Бүртгэлд тусгаагүй, санхүүжилт 30% дутуу
Он дамжин хэрэгжих ТАХ-ний дүн						325.5	1	325.5					
34	Гурванбулаг сумын ЗДТГ-ын барилгын засвар	Шилжих	2024	2024	Их засвар	120.0				үгүй	үгүй	үгүй	Улсын комисс хүлээж аваагүй.
35	Ахуйн үйлчилгээний барилгын гадна бохирын системийн угсралтын ажил (Гурванбулаг сум)	Шинэ	2024	2024	Их засвар	126.0				үгүй	үгүй	үгүй	Тендерийг 9 удаа зарласан ч амжилтгүй болсон
36	ЕБСургуулийн сантехникийн засвар (Дашинчилэн сум)	Шинэ	2024	2024	Их засвар	30.0				үгүй	үгүй	үгүй	Тендерийг 5 удаа зарласан ч амжилтгүй болсон
37	МСҮТ-ийн барилгын засварын орон нутгийн оролцооны хөрөнгө (Булган сум)	Шинэ	2024	2024	Их засвар	68.7				үгүй	үгүй	үгүй	Тендерийг 3 удаа зарласан ч амжилтгүй болсон
38	Сумын төвийн хатуу хучилттай авто зам барих ажлын үргэлжлэл (Тэшиг сум)	Шинэ	2024	2024	Авто зам, дэд бүтэц	300.0				үгүй	үгүй	үгүй	Тендерийг 6 удаа зарласан, 2024 оны 12 сард гэрээ хийх эрх олгосон

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2024 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

39	Цэвэр усан хагамжийн угсралтын ажлын дутуу санхүүжилт	Шинэ	2024	2024	Барилга байгууламж	30.0			үгүй	Үгүй	үгүй	Өмнөх оны үлдэгдэл
40	0.4 КВТ цахилгаан дамжуулах шугамын ажлын санхүүжилт (Баян-Агт сум)	Шинэ	2024	2024	Барилга байгууламж	40.0	Бошголсон ХХК	59.0	үгүй	Үгүй	үгүй	Гэрээг 2024 оны 12 дугаар сард хийсэн
41	Сумын төвийн гэрэлтүүлэг (Баян-Агт)	Шинэ	2024	2024	Барилга байгууламж	50.0			үгүй	Үгүй	үгүй	Зураг төсөвгүй
42	Усан шүүлтүүртэй халаалтын тогоо шинэчлэх 1,8мвт (Хутаг-Өндөр сум)	Шинэ	2024	2024	Тоног. төхөөрөмж	120.0	Бэсүжин констракшн ХХК	105.2	үгүй	Үгүй	үгүй	Тендерийг 3 удаа зарласан, гэрээг 2024 оны сүүлчээр хийсэн
43	Аймгийн Засаг даргын тамгын газрын лифтний тоноглол, засвар	Шинэ	2024	2025	Тоног. төхөөрөмж	70.0			үгүй	Үгүй	үгүй	
44	Лед дэлгэц шинээр худалдаж авах (Баян-агт сум)	Шинэ	2024	2025	Тоног. төхөөрөмж	40.0			үгүй	Үгүй	үгүй	Тендерийг 2 удаа зарласан, 2024 оны 12 сард гэрээ хийх эрх олгосон
Гүйцэтгэл гараагүй ТАХ-ний дүн						994.7	2	164.2			-	
Нийт дүн						5,450.6	38	4,731.5			2,538.1	

-oOo-

